



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/287

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Туул голын сав газрын захиргааны удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Туул голын сав газрын захиргааны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2017\0222SAG3.Docx
УХАА 122

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:

Газрын дарга: Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Аудитор: Д.Ганбилэг
Утас: 260512

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

Монгол Улсын Үндэсний аудитын газар
Монгол Улс,
Чингэлтэй дүүрэг
Бага тойруу
Засгийн газрын IY байр

Цахим хуудас: www.mnao.mn



Гроут финанс аудит ХХК

Гүйцэтгэх захирал
Б.Бямба
Аудитын менежер:
Э.Мөнхтогтох
Утас: 99094391

Цахим хаяг:
info@growthfinance.mn

Гроут финанс Аудит ХХК-ийн хаяг:
Улаанбаатар 16030, Баянгол дүүрэг,
3-р хороо Үйлдвэрийн бүс,
Энгельсийн гудамж 11-191 тоот

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн Санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Агуулга

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дах заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Туул голын сав газрын захиргаа”-ны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд (ҮАГ-САГ/2017/262/СТА-ТШЗ) аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын гарын авлага, Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрэм, аудитын ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бусад дүрэм журмын мөрдөж ажиллан төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Туул голын сав газрын захиргаа”-ны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт \УСНББОУС\, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Үндэсний аудитын газрын үүрэг юм.

“Туул голын сав газрын захиргаа”-ны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 10 дугаар сарыг 19-нд анхны уулзалтаа хийж, аудитад шаардлагатай баримтын жагсаалтыг хүргүүлсэн, санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-аас эхлэж 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн “Гроут финанс Аудит” ХХК хэрэгжүүлэв.

“Туул голын сав газрын захиргаа” нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 25-нд “Гроут финанс Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Гроут финанс Аудит” ХХК нь аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдрөөс 2014 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 20-нд “Туул голын сав газрын захиргаа” байгууллагын удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Туул голын сав газрын захиргаа” нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай, Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн , Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын

хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Ашигт малтмалын тухай хуулиуд болон холбогдох хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, тогтоол шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

БОНХАЖЯ-ны Сайдын 2013 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А-167 дугаар тушаалаар ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг баталж тус байгууллагад хамааралтай тарифыг 305,000 төгрөг гэж тогтоож байсан ба 2015 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн А/323 дугаар тушаалаар уг тарифыг өөрчилж 490,000 төгрөг болгосон. 2016 оны хувьд уг тарифыг мөрдсөн хэвээр байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага юм.

Төрөөс усны талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх стратегийн зорилтын хүрээнд “Ус” үндэсний хөтөлбөр болон “Хатан туул” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Усны тухай болон холбогдох хууль болон Ус бохирдуулсаны төлбөрийн тухай тогтоомжийг хэрэгжүүлэх стратеги зорилтуудын хүрээнд дэвшүүлсэн зорилт тус бүрд тодорхой ажлуудыг хийж үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх стратеги зорилтын хүрээнд хүн амыг баталгаат ундны усаар хангаж, ахуйн бохир ус цэвэрлэгээний түвшинг дээшлүүлж, ариун цэврийн байгууламжийг сайжруулах, хөдөө аж ахуйн ус хангамжийн нөхцөлийг сайжруулах, үйлдвэр, уул уурхай, эрчим хүчний ус хангамж, бохир ус цэвэрлэгээг оновчтой шийдвэрлэх, хүрээлэн буй орчны ус ба сав газрын экосистемийн тэнцвэрт байдлыг тогтвортой хадгалах, сав газрын усны менежментийн таатай орчин бүрдүүлэх зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа төлөвлөн гүйцэтгэсэн байна.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Туул голын сав газрын захиргаа байгууллагын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 11-г гүйцэтгэв. Тус байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогогүй байна.

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Asolous програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Туул голын сав газрын захиргаа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

5. Материаллаг байдлын түвшин:

Туул голын сав газрын захиргаа нь 100 хувь төсвөөс санхүүждэг ба нийт зардлын хэмжээ хэмжээ 441,8 сая төгрөгийн 1 хувиар материаллагын түвшинг тооцох нь зохимжтой гэж үзэж, 4,4 сая төгрөгөөр тооцлоо.

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Туул голын сав газрын захиргаа байгууллагын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэнээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Туул голын сав газрын захиргаа 2016 онд урсгал зардалд 364,4 сая төгрөг төлөвлөснөөс 353,5 сая төгрөгийг санхүүжилтээр, 14,2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтээр авч, 22,4 сая төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоор олсон. Үүнээс 359,8 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж 30,3 сая төгрөгийн хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар тодорхой тусгана. Тус хуулийн 5.1-т заасны дагуу Туул голын сав газрын захиргаа өөрийн цахим хуудас болох <http://www.tuulgol.mn/> сайтад байршуулан ажиллаж байна. Байгууллагын 2016 оны төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ мэдээллийг тогтсон цаг хугацаанд шилэн дансны цахим хуудас болон байгууллагын вэб хуудас, мэдээллийн самбарт байршуулснаар Захиргааны болон олон нийтийг байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Орлого, зардал, хөрөнгийн дансдууд 100 хувь хамрагдав. Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 49 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал:

БОНХАЖЯ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 199,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоног төхөөрөмжийн дансанд бүртгэснийг, ангилалаар нь салгаж 75,3 сая төгрөгийн байгууламжийг барилга байгууламж дансанд, 335,2 мянган төгрөгийг биет бус хөрөнгийн дансанд бичиж санхүүгийн тайланд залруулсан.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар зарим зардлын батлагдсан төсвөөс хэтэрсэн хэсгийг хэмнэлттэй өөр зардлаар тайлагнах буюу өөрөөр хэлбэл зарим зардлыг ангилалын хувьд зөрүүтэй илэрхийлсэн байна. Эдгээр нь 5 ажил гүйлгээгээр 14,2 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба тэдгээрийн дотор 12,3 сая төгрөгийн хоол унааны зардлыг цалингийн зардлаар тайлагнасныг залруулахаар байгаа боловч Төрийн сангийн ажилтан гүйцэтгэл гаргахад зөвшөөрөхгүй гэсэн байдлаар зөрүүтэй тайлагнаж ирсэн байна.

10. Гол онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

“Туул голын сав газрын захиргаа”-ны 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим сорилын аргаар шалгалаа. \СТА-5\ Мөн дансны үлдэгдлийг тулган шалгах, авлага өглөгийн тулган баталгаажуулалт, үндсэн хөрөнгийн тооллого, төсвийн гүйцэтгэлийн тайланд шинжилгээ хийх, татвар нийгмийн даатгалын тайлангуудыг шалгасан.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад илэрсэн алдаа дараах байдлаар шийдвэрлэсэн. Үүнд: 199,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авахдаа 75,0 сая төгрөгийн 10 ш хяналтын цооногийг буюу байгууламжийн шинжтэй хөрөнгийг, 335,3 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг тоног төхөөрөмж дансанд бүртгэсэн,.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд зохих дансанд залруулсан

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар зарим төсөвт тусгагдаагүй, зардал хооронд гүйлгэн зарцуулсан 5-н ажил гүйлгээгээр нийт 14,2 сая төгрөгийн зардлыг зориулалтын бус зардлаар илэрхийлсэн. Үүний дотор 12,3 сая төгрөгийн хоол унааны зардлыг цалингийн зардлаар тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн

12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад 1,9 сая төгрөгийн залруулагдаагүй материаллаг бус алдаа зөрчил байна. Энэ нь тухайн зардлыг гүйлгэж болох өөр зардалаас гаргасан бөгөөд төрийн сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээтэй зөрөх учир залруулах боломжгүй гэж “Туул голын сав газрын захиргаан”-ны нягтлан бодогч тайлбарласан.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Туул голын сав газрын захиргаан”-нд БОНХАЖЯ-аас шилжиж ирсэн хөрөнгийн ашиглалтад хяналт тавих. Цаашид үндсэн хөрөнгө болон бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгийн шинж чанар, цаашид ашиглах байдлыг дахин шинжилж, ангиллыг зориулалт болон шинж чанарын дагуу үнэн зөв ангилах. Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Тус байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Туул голын сав газрын захиргааны 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 89,5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 14,2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 75,3 сая төгрөгөөр санхүүгийн тайланг залруулсан.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн шууд захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд “Троут финанс Аудит” ХХК аудит хийж 4 зөвлөмж өгсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

17. Аудитын гэрчилгээний зөрчилгүй дүгнэлтийн санал

“Туул голын сав газрын захиргаа”-ны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Газрын дарга: Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Аудитор: Д.Ганбилэг
Утас: 260512



Гроут финанс аудит ХХК

Гүйцэтгэх захирал
Б.Бямба
Аудитын менежер:
Э.Мөнхтогтох
Аудитор:
Б.Даваасүрэн
Утас: 99094391, 99063227

Цахим хаяг:
info@growthfinance.mn

Гроут финанс Аудит ХХК-ийн хаяг:
Улаанбаатар 16030, Баянгол дүүрэг,
3-р хороо Үйлдвэрийн бүс, Энгельсийн
гудамж 11-191 тоот

Менежментийн захидал

Асуудал 1 Санхүүгийн тайлангийн эхний
үлдэгдэл зөрүүтэй байгаа талаар

Асуудал 2. Ангилал зөрүүтэй илэрхийлсэн
зардал

Асуудал 3. Батлагдсан төсвөөс хэтэрсэн хоол
унааны зардал

Асуудал 4. Үндсэн хөрөнгийн ангилал

Асуудал 5. Төлөвлөгөөнд тусгадаггүй орлого

Асуудал 1 Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийн зөрүү

Ажиглалт

БОАЖЯамны багцийн санхүүгийн нэгдсэн тайланд өөрчлөлт оруулах шаардлагын үүднээс тус байгууллагын 2015 оны Санхүүгийн тайланг баталгаажуулан аудитын гэрчилгээ гарсаны дараа авлагын үлдэгдлийг өөрчилж, 982,5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 6.2.5-д заасан “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх.” гэсэн заалтыг зөрчихөд хүргэж байна

Эрсдэл

Санхүүгийн тайланд авлага болон орлогыг зөрүүтэй илэрхийлэх, төсвийн тухай хууль зөрчсөнөөс хуулийн хариуцлага хүлээх.

Иж бүрэн, үнэн зөв болон батламж мэдэгдлийг хангахгүй байх

Зөвлөмж

Аудитын санхүүгийн тайланг баталгаажуулснаас хойш өөрчлөлт орвол түүнийг дараа жилийн санхүүгийн тайланд залруулах ба шаардлагатай гэж үзвэл аудитласан тайланд өөрчлөлт оруулсаны дараа уг өөрчлөлтийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитласан санхүүгийн тайланг яаманд тушаасны дараа Сангийн сайдын тушаал гарч яамны багцийн тайланд өөрчлөлт орсон гэсэн шалтгааны үндсэн дээр манай байгууллагыг санхүүгийн тайландаа уг авлагыг нэмж бүртгэх хэрэгтэй гэсэн чиглэл өгсөний дагуу уг өөрчлөлтийг оруулж өмнөх жилийн яамны багцийн тайланд нэгтгүүлсэн.

Асуудал 2. Ангилал зөрүүтэй илэрхийлсэн зардал

Ажиглалт

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 769,4 мянган төгрөгийн гэрэл цахилгааны зардлыг түлш халаалтын зардлаар, хүүхдийн баярын бэлгийн зориулалтаар нэг хүүхдэд 41,0 мянган төгрөгөөр тооцож нийт 984,0 мянган төгрөг зарцуулсны 522,0 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаар, 395,0 мянган төгрөгийг бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаар, интернет дата эрхийн сунгалтын төлбөрийн 211,2 мянган төгрөгийг бичиг хэргийн зардлаар тус тус тайлагнасан.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6.5.3-заасан “төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах” гэсэн заалтыг зөрчихөд хүргэж байна

Эрсдэл

Санхүүгийн тайланд зардлын гүйцэтгэлийг зөрүүтэй илэрхийлэх, үүний улмаас дараа оны төсвийг бодитоор төлөвлөхөд тооцооллын зөрүү үүссэнээс төсөв үндэслэлгүй батлагдах зэрэг эрсдэлтэй.

Иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байх

Зөвлөмж

Төсвийн тухай хуульд зааснаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулж тайлагнана.

“Төсвийн санхүүжилтын болон зарцуулалтын эрхийн журам”-ын дагуу зардлын бүлгийн дүнд зохицуулалт хийсэн бол тэр хэмжээгээр батлагдсан төсөвт өөрчлөлт орж төсвийг зориулалтын дагуу тайлагнахад уг зардал батлагдсан төсвөөс хэтрэхгүй байхаар зохион байгуулах.

Үйлчлүүлэгчийн хариу

Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журамд заасан “Төсвийн байгууллага нь зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангилалын дагуу зардал гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн өр төлбөр үүсгэхгүйгээр хөтөлбөр, арга хэмжээний зорилтыг бүрэн хангахаар төсвийг зарцуулна” гэсэн заалтын дагуу Төрийн санд хүсэлт гарган тэдгээр зардлын санхүүжилтыг хэмнэгдсэн зардлаас гаргаж гүйлгээ эрхийг нээлгэн авсан ба гүйцэтгэлийг санхүүжилтын хуваарь төлөвлөгөөний дагуу тайлагнах ёстой гэсэн төрийн сангийн мэргэжилтний шаардлагын дагуу тайлагнасан. Хууль болон журмыг зөрчсөн гэж үзвэл бид залруулан зардлыг зориулалтын дагуу тайлагнаж залруулах боломжтой.

Асуудал 3 Батлагдсан төсвөөс хэтэрсэн хоол унааны зардал

Ажиглалт

Тайлант хугацаанд 4-5 ажилтанд эхийн чөлөөтэй байснаас цалингийн зардал батлагдсан төсвөөс хэмнэгдсэн, уг хэмнэгдсэн зардлаас байгууллагын даргын 2016 оны Б-31 дүгээр тушаалаар ажилтнуудад олгох хоол, унааны мөнгийг 13,0 мянган төгрөгөөр тогтоож олгосноос батлагдсан төсөвт тусгагдсан хоол унааны зардлыг 12.3 сая төгрөгөөр хэтрүүлэн түүнийгээ цалин хөлсний зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

Төсвийн тухай хуулийг зөрчих, төсвийн хэмнэлтийн талаар гарсан төрийн дээд байгууллагын бодлого шийдвэрийг зөрчих, Эрх ба үүрэг, үүрэг ба хариуцлага батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж

Төсвийн тухай хуульд зааснаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулж тайлагнана. Төрийн албаны тухай хуулийн ажилтнуудад унаа зардлыг олгохдоо Төрийн албаны тухай хуулийн 27.1.3-т заасан “гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь шинж байдлыг харгалзан зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг нөхөн авах;” гэсэн заалтыг мөрдлөг болгох.

Үйлчлүүлэгчийн хариу

Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журамд заасны дагуу төсөвт зохицуулалт хийж төсвийг зориулалтын дагуу тайлагнаж байна.

Асуудал 4: Үндсэн хөрөнгийн ангилал

Ажиглалт

2016 онд БОАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар ирсэн нийт 199,0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан ба түүний дотор 123.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 75,0 сая төгрөгийн хяналтын цооног буюу байгууламж, 335,3 мянган төгрөгийн программ хангамж буюу биет бус хөрөнгийг тоног төхөөрөмжийн дансанд бүртгэж, ашиглалтын хугацааг 5 жилээр тогтоон элэгдлийн зардал 5,6 сая төгрөгөөр илүү тооцсон нь үр дүнд нөлөөлж байна.

Эрсдэл

Санхүүгийн тайланд хөрөнгийн ангилалыг буруу илэрхийлснээр тухайн хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаа болон үлдэгдэл өртгийг зөрүүтэй илэрхийлнэ.

Үнэн зөв, тодруулга ба тайлагнал зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Зөвлөмж

Үндсэн хөрөнгийг ашиглах байдал, зориулалтын дагуу үнэн зөв ангилж бүртгэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын залруулгын дагуу залруулж санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлсэн.

Асуудал 5: Төлөвлөгөөнд тусгадаггүй орлого

Ажиглалт

2016 онд БОАЖЯ-ны 2015 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн А/323 дугаар тушаалаар тогтоосон тарифын дагуу ус ашиглах дүгнэлтийн орлого 22,4 сая төгрөг олсон. Төсвийн төлөвлөгөөнд үйл ажиллагааны орлогыг тусгаж өгөөгүй байна.

Эрсдэл

Үндсэн үйл ажиллагааны орлогыг төсөвт тусгаж холбогдох зардалд төлөвлөж өгөөгүйгээс төсвийн санхүүжилт тэр хэмжээгээр илүү тооцогдоно.

Үнэн зөв, тодруулга ба тайлагнал зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Зөвлөмж

Үндсэн үйл ажиллагаанаас олох орлогыг төсөвт тусгаж байх

Үйлчлүүлэгчийн хариу

Үндсэн үйл ажиллагаанаас олох орлого улсын төсвийн орлогод ордог тул Сангийн яам төлөвлөгөө тавьж өгдөггүй болно.

Туул голын сав газрын захиргааны 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх

Аудит хийгдсэн Санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Залруулга	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,001,668.63	28,433,072.49		28,433,072.49
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-		-
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-		-
Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-		-
Төрийн сангийн харилцах	-	-		-
АВЛАГА	3,936,516.14	-		-
Төлбөртэй үйлчилгээний авлага	2,940,000.00	-		-
Татаас санхүүжилтийн авлага	982,516.14	-		-
Хувь хүмүүсээс авах авлага	14,000.00	-		-
Зээлийн авлага	-	-		-
БАРАА МАТЕРИАЛ	25,065,152.49	28,433,072.49		28,433,072.49
Хангамжийн материал	25,065,152.49	28,433,072.49		28,433,072.49
Бичиг хэргийн материал	990,030.00	1,310,250.00		1,310,250.00
Аж ахуйн материал	21,632,122.49	24,390,822.49		24,390,822.49
Сэлбэг хэрэгсэл	2,443,000.00	2,443,000.00		2,443,000.00
Түлш шатах тослох материал	-	289,000.00		289,000.00
ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	141,587,691.00	280,817,086.18		286,433,704.54
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-		-
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	141,587,691.00	280,817,086.18		286,433,704.54
Газар	-	-		-
Биет хөрөнгө	141,411,232.79	280,817,086.18	5,616,618.36	286,140,346.80
Барилга, байгууламж	80,264,075.19	80,264,075.19	75,000,000.00	155,264,075.19
Хуримтлагдсан элэгдэл	(16,282,716.99)	(20,295,920.79)	(1,875,000.00)	(22,170,920.79)
Авто тээврийн хэрэгсэл	129,689,144.37	129,689,144.37		129,689,144.37
Хуримтлагдсан элэгдэл	(105,962,279.37)	(120,341,636.73)		(120,341,636.73)
Машин, тоног төхөөрөмж	166,181,772.50	369,161,726.30	(75,335,266.00)	293,826,460.30
Хуримтлагдсан элэгдэл	(134,702,474.49)	(176,070,278.26)	7,533,526.62	(168,536,751.64)
Тавилга, аж ахуйн эд хогшил	37,301,156.44	37,301,156.44		37,301,156.44
Хуримтлагдсан элэгдэл	(15,346,761.86)	(19,160,497.34)		(19,160,497.34)
Номын фонд	269,317.00	269,317.00		269,317.00
Биет бүс хөрөнгө	176,458.21	-		293,357.74
Програм хангамж	770,000.00	770,000.00	335,266.00	1,105,266.00
Хасагдуулга	(593,541.79)	(770,000.00)	(41,908.26)	(811,908.26)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	170,589,359.63	309,250,158.67		314,866,777.03
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	385,056.00	-		-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	385,056.00	-		-
Өглөг	385,056.00	-		-
Ажиллагчидтай холбогдсон өглөг	385,056.00	-		-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	170,204,303.63	309,250,158.67	5,616,618.36	314,866,777.03
Засгийн газрын хувь оролцоо	170,204,303.63	309,250,158.67		314,866,777.03
Засгийн газрын оруулсан капитал /ЗГ Сан/ орон нутгийн сан	346,824.00	346,824.00		346,824.00
Өмч: -Төрийн өмч	346,824.00	346,824.00		346,824.00
Хуримтлагдсан үр дүн	169,857,479.63	308,903,334.67		314,519,953.03
Өмнөх үеийн үр дүн	169,857,479.63	169,857,479.63		169,857,479.63
Тайлант үеийн үр дүн	-	139,045,855.04	5,616,618.36	144,662,473.40
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	170,589,359.63	309,250,158.67		314,866,777.03

Туул голын сав газрын захиргааны 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх

Аудит хийгдсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Залруулга	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	324,188,593.87	586,479,751.80		586,479,751.80
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,922,809.73	219,380,153.80		219,380,153.80
Төсөвт байгууллагын өөрийн орлого	29,922,809.73	219,380,153.80		219,380,153.80
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,450,000.00	19,475,000.00		19,475,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,472,809.73	199,905,153.80		199,905,153.80
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	294,265,784.14	367,099,598.00		367,099,598.00
Улсын төвлөрсөн төсвөөс	289,225,330.00	353,475,998.00		353,475,998.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	289,225,330.00	353,475,998.00		353,475,998.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	5,040,454.14	13,623,600.00		13,623,600.00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө	-	10,000,000.00		10,000,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн хөрөнгө	4,403,178.00	3,623,600.00		3,623,600.00
Төсвийн урамшуулал	637,276.14	-		-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	366,688,879.72	447,433,896.76		441,817,278.40
УРСГАЛ ЗАРДАЛ	322,992,338.63	362,812,543.63		357,195,925.27
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,992,338.63	362,812,543.63		357,195,925.27
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	208,820,611.14	217,598,431.97		217,598,431.97
Цалин	192,320,611.14	199,811,431.97		199,811,431.97
Унаа хоолны хөнгөлөлт	16,500,000.00	17,787,000.00		17,787,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,533,132.92	25,013,790.49		25,013,790.49
Тэтгэврийн даатгалын шимтгэл	15,128,674.02	16,269,388.65		16,269,388.65
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,731,272.53	1,782,057.97		1,782,057.97
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,085,370.73	2,175,732.46		2,175,732.46
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	417,074.18	435,146.49		435,146.49
Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,170,741.46	4,351,464.92		4,351,464.92
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,312,311.26	17,681,709.03		17,681,709.03
Гэрэл цахилгааны зардал	9,644,432.00	9,796,334.00		9,796,334.00
Түлш, халаалтын зардал	6,667,879.26	7,885,375.03		7,885,375.03
Хангамж, бараа материалын зардал	10,287,938.75	13,835,123.52		13,835,123.52
Бичиг хэргийн материал	2,215,812.00	2,611,980.00		2,611,980.00
Тээвэр, шатахууны зардал	2,523,800.00	5,753,000.00		5,753,000.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	3,839,298.51	4,179,693.52		4,179,693.52
Ном, хэвлэлийн зардал	392,900.00	-		-
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,316,128.24	1,290,450.00		1,290,450.00
Нормативт зардал	129,950.00	-		-
Нормын хувцас, зөөлөн эдтэл	129,950.00	-		-
Эд хогшил, урсгал засварын зардал	2,269,900.00	2,897,700.00		2,897,700.00
Багаж хэрэгсэл	-	161,000.00		161,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	460,500.00	-		-
Урсгал засвар	1,809,400.00	2,736,700.00		2,736,700.00
Томилолт, зочны зардал	4,344,807.00	12,027,170.00		12,027,170.00
Дотоод томилолтын зардал	4,344,807.00	12,027,170.00		12,027,170.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	824,025.00	8,964,060.00		8,964,060.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	310,000.00	6,457,100.00		6,457,100.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	1,500,000.00		1,500,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	245,025.00	320,760.00		320,760.00
Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00		150,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	53,000.00	200,000.00		200,000.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	66,000.00	336,200.00		336,200.00
Бараа үйлчилгээний бусад зардал	56,469,662.56	64,794,558.62	(5,616,618.36)	59,177,940.26
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,311,160.00	1,044,000.00		1,044,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөргөлдөл	55,158,502.56	63,750,558.62	(5,616,618.36)	58,133,940.26
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,696,541.09	84,621,353.13		84,621,353.13
Бусад урсгал шилжүүлэг	12,257,378.00	54,307,898.00		54,307,898.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,313,178.00	430,000.00		430,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,944,200.00	53,877,898.00		53,877,898.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,439,163.09	30,313,455.13		30,313,455.13
Төвлөрүүлэх шилжүүлэг	31,439,163.09	30,313,455.13		30,313,455.13
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(42,500,285.85)	139,045,855.04	5,616,618.36	144,662,473.40
НИЙТ ҮР ДҮН (VI=III+V)	(42,500,285.85)	139,045,855.04	5,616,618.36	144,662,473.40

Туул голын сав газрын захиргааны 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх

Аудит хийгдсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын сан	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Залруулга	Залруулсан дүн
2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	-	-	-
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-	-
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	346,824.00	169,857,479.63	170,204,303.63	-	170,204,303.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,824.00	169,857,479.63	170,204,303.63	-	170,204,303.63
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	139,045,855.04	139,045,855.04	5,616,618.36	144,662,473.40
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	346,824.00	308,903,334.67	309,250,158.67	-	314,866,777.03

Туул голын сав газрын захиргааны 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх

Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Залруулга	Залруулсан дүн
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	311,121,024.14	390,151,874.14		390,151,874.14
Төсөвт байгууллагын өөрийн орлого	16,510,000.00	22,415,000.00		22,415,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,510,000.00	22,415,000.00		22,415,000.00
Бусад орлого	345,240.00	-		-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	294,265,784.14	367,736,874.14		367,736,874.14
Улсын төвлөрсөн төсвөөс	293,628,508.00	353,475,998.00		353,475,998.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	293,628,508.00	353,475,998.00		353,475,998.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	637,276.14	14,260,876.14		14,260,876.14
ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	10,000,000.00		10,000,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	3,623,600.00		3,623,600.00
Төсвийн урамшуулал	637,276.14	637,276.14		637,276.14
НИЙТ ЗАРЛАГ А ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	309,187,524.14	387,077,074.14		387,077,074.14
УРСГАЛ ЗАРДАЛ	309,187,524.14	387,077,074.14		387,077,074.14
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,508,466.91	302,455,721.01		302,455,721.01
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	207,623,787.85	218,400,462.32		218,400,462.32
Үндсэн цалин	191,123,787.85	200,613,462.32		200,613,462.32
Унаа хоолны хөнгөлөлт	16,500,000.00	17,787,000.00		17,787,000.00
Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	22,834,837.29	24,237,576.14		24,237,576.14
Тэтгэврийн даатгалын шимтгэл	14,522,813.49	17,148,679.74		17,148,679.74
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,703,282.01	1,417,779.08		1,417,779.08
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,065,238.17	1,772,224.38		1,772,224.38
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	413,027.52	354,444.25		354,444.25
Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,130,476.10	3,544,448.69		3,544,448.69
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,312,311.26	17,681,709.03		17,681,709.03
Гэрэл цахилгааны зардал	9,644,432.00	9,796,334.00		9,796,334.00
Түлш, халаалтын зардал	6,667,879.26	7,885,375.03		7,885,375.03
Хангамж, бараа материалын зардал	8,633,088.51	14,502,043.52		14,502,043.52
Бичиг хэрэг	1,591,150.00	2,815,700.00		2,815,700.00
Тээвэр, шатахуун	2,400,800.00	6,042,000.00		6,042,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,839,298.51	4,154,693.52		4,154,693.52
Ном, хэвлэл	392,900.00	-		-
Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	408,940.00	1,489,650.00		1,489,650.00
Нормативт зардал	204,800.00	589,000.00		589,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	204,800.00	589,000.00		589,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,411,900.00	5,009,700.00		5,009,700.00
Багаж техник хэрэгсэл	-	574,600.00		574,600.00
Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	835,500.00	1,698,400.00		1,698,400.00
Урсгал засвар	1,576,400.00	2,736,700.00		2,736,700.00
Томилолт, зочны зардал	4,344,807.00	12,027,170.00		12,027,170.00
Дотоод албан томилолт	4,344,807.00	12,027,170.00		12,027,170.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	824,025.00	8,964,060.00		8,964,060.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	310,000.00	6,457,100.00		6,457,100.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,500,000.00		1,500,000.00
Даатгалын үйлчилгээ	245,025.00	320,760.00		320,760.00
Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00		150,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	53,000.00	200,000.00		200,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	66,000.00	336,200.00		336,200.00
Бараа үйлдвэрлэлийн бусад зардал	1,318,910.00	1,044,000.00		1,044,000.00
Хичээл үйлдвэрлэлийн далдлаг хийх	1,318,910.00	1,044,000.00		1,044,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,679,057.23	84,621,353.13		84,621,353.13
Бусад урсгал шилжүүлэг	12,257,378.00	54,307,898.00		54,307,898.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,313,178.00	430,000.00		430,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,944,200.00	53,877,898.00		53,877,898.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,421,679.23	30,313,455.13		30,313,455.13
Төвлөрүүлэх шилжүүлэг	32,421,679.23	30,313,455.13		30,313,455.13
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,933,500.00	3,074,800.00		3,074,800.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,933,500.00	3,074,800.00		3,074,800.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,933,500.00	3,074,800.00		3,074,800.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮГ/	1,933,500.00	3,074,800.00		3,074,800.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,933,500.00)	(3,074,800.00)		(3,074,800.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-		-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-		-
Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		-
Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		-

Туул голын сав газрын захиргааны 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх

Аудит хийгдсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Залруулга	Залруулсан дүн	Зөрүү
	-	-		-	
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	364,447,100.00	345,603,742.87		345,603,742.87	18,843,357.13
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	364,447,100.00	345,603,742.87		345,603,742.87	18,843,357.13
Бараа, үйлчилгээний зардал	299,785,400.00	291,725,844.87		291,725,844.87	8,059,555.13
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,603,300.00	218,400,462.32		218,400,462.32	202,837.68
Үндсэн цалин	200,816,300.00	200,613,462.32		200,613,462.32	202,837.68
Нэмэгдэл	-	-		-	-
Унаа, болон бусад нөхөн олговор	17,787,000.00	17,787,000.00		17,787,000.00	-
Урамшуулал	-	-		-	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,046,300.00	24,046,300.00		24,046,300.00	-
Тэтгэврийн даатгал	15,339,400.00	16,957,403.60		16,957,403.60	(1,618,003.60)
Тэтгэмжийн даатгал	1,711,900.00	1,417,779.08		1,417,779.08	294,120.92
ҮОМШӨ ний даатгал	2,185,900.00	1,772,224.38		1,772,224.38	413,675.62
Ажилгүйдлийн даатгал	437,100.00	354,444.25		354,444.25	82,655.75
Эрүүл мэндийн даатгал	4,372,000.00	3,544,448.69		3,544,448.69	827,551.31
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,307,300.00	17,681,709.03		17,681,709.03	5,625,590.97
Гэрэл цахилгаан	11,837,400.00	9,796,334.00		9,796,334.00	2,041,066.00
Түлш, халаалт	11,469,900.00	7,885,375.03		7,885,375.03	3,584,524.97
Хангамж, бараа материалын зардал	11,462,500.00	11,462,043.52		11,462,043.52	456.48
Бичиг хэрэг	2,954,300.00	2,265,700.00		2,265,700.00	688,600.00
Тээвэр (шатахуун)	3,552,600.00	3,552,000.00		3,552,000.00	600.00
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,155,600.00	4,154,693.52		4,154,693.52	906.48
Бага үнэтэй, түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс	800,000.00	1,489,650.00		1,489,650.00	(689,650.00)
Нормативт зардал	600,000.00	589,000.00		589,000.00	11,000.00
Нормын хувцас зөөлөн эдгэл	600,000.00	589,000.00		589,000.00	11,000.00
Эд хогшил худалдан авах	9,600,200.00	8,084,500.00		8,084,500.00	1,515,700.00
Багаж, техник, хэрэгсэл	3,649,400.00	3,649,400.00		3,649,400.00	-
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,363,600.00	1,698,400.00		1,698,400.00	665,200.00
Урсгал засвар	3,587,200.00	2,736,700.00		2,736,700.00	850,500.00
Томилолт, зочны зардал	6,921,800.00	6,825,170.00		6,825,170.00	96,630.00
Дотоод албан томилолт	6,921,800.00	6,825,170.00		6,825,170.00	96,630.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,200,000.00	3,592,660.00		3,592,660.00	607,340.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00	1,085,700.00		1,085,700.00	414,300.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	1,500,000.00		1,500,000.00	-
Даатгалын үйлчилгээ	500,000.00	320,760.00		320,760.00	179,240.00
Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00		150,000.00	-
Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	200,000.00		200,000.00	-
Мэдээллийн технологийн зардал	350,000.00	336,200.00		336,200.00	13,800.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,044,000.00	1,044,000.00		1,044,000.00	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,044,000.00	1,044,000.00		1,044,000.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,661,700.00	53,877,898.00		53,877,898.00	10,783,802.00
Бусад урсгал шилжүүлэг	64,661,700.00	53,877,898.00		53,877,898.00	10,783,802.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	150,000.00	-		-	150,000.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,511,700.00	53,877,898.00		53,877,898.00	10,633,802.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	364,447,100.00	353,475,998.00		353,475,998.00	10,971,102.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	364,447,100.00	353,475,998.00		353,475,998.00	10,971,102.00
Улсын төсвөөс санхүүжих	364,447,100.00	353,475,998.00		353,475,998.00	10,971,102.00
АЖИЛЛАГСДЫН ТОО	23	23		23	-
Удирдах ажилтан	1	1		1	-
Гүйцэтгэх ажилтан	18	18		18	-
Үйлчлэх ажилтан	4	4		4	-
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1	-		-	1
Төрийн захиргааны албан хаагч /ТЗ/	19	19		19	-
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	4	4		4	-

Туул голын сав газрын захиргааны 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх
Аудит хийгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Залруулга	Залруулсан дүн	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		-	
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	14,234,676.14		14,234,676.14	
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	14,234,676.14		14,234,676.14	
210	Бараа, үйлчилгээний зардал	-	13,804,676.14		13,804,676.14	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	191,276.14		191,276.14	
210201	Тэтгэврийн даатгал	-	191,276.14		191,276.14	
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,040,000.00		3,040,000.00	
210401	Бичиг хэрэг	-	550,000.00		550,000.00	
210402	Тээвэр (шатахуун)	-	2,490,000.00		2,490,000.00	
2107	Томилолт, зочны зардал	-	5,202,000.00		5,202,000.00	
210702	Дотоод албан томилолт	-	5,202,000.00		5,202,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	5,371,400.00		5,371,400.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	5,371,400.00		5,371,400.00	
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	430,000.00		430,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	430,000.00		430,000.00	
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	430,000.00		430,000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	36,675,876.14		36,675,876.14	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	22,415,000.00		22,415,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	22,415,000.00		22,415,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	14,260,876.14		14,260,876.14	
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилал	-	10,000,000.00		10,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс	-	3,623,600.00		3,623,600.00	
131106	Төсвийн урамшуулал	-	637,276.14		637,276.14	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		0	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	23		23	
620001	Удирдах ажилтан	-	1		1	
620002	Гүйцэтгэх ажилтан	-	18		18	
620003	Үйлчлэх ажилтан	-	4		4	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-				
650001	Төрийн захиргааны албан хаагч /ТЗ/	-	19		19	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	-	4		4	